



Өвөрхангай аймгийн Засаг даргын
дэргэдэх Статистикийн хэлтэс



Үйлдвэр үйлчилгээний салбарын өнөөгийн байдал



Арвайхээр

ГАРЧИГ

1. Аймгийн аж үйлдвэр барилгын салбарын үүсэл хөгжил 3
2. Аймагт бүртгэлтэй ААНэгжийн тоо 4-5
3. Сүүлийн жилүүдэд аж үйлдвэр, барилга үйлчилгээний салбарт гарч байгаа гол онцлог өөрчлөлт6
4. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт7-8
5. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн борлуулалт9
6. Аймгийн газар зүйн байршил зах зээлд ойр эсэх 10-11
7. Аймгийн дэд бүтцийн хөгжил 12
8. Гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 13
9. Хангайн бүсийн аймгуудын дотоодын нийт бүтээгдэхүүн,14
10. Аж үйлдвэрийн салбарт ажилласадын хувь 15-16
11. Барилгын салбарын нийт үйлдвэрлэлт, их засварын ажлууд 17-18
12. Аж үйлдвэр, барилгын салбарын хөдөлмөрийн бүтээмж19
13. Худалдааны салбарын нийт бараа гүйлгээ, цэгийн тоо20-22
14. Тээврийн салбарын тээсэн ачаа, зорчигч эргэлт23-24
15. Холбоо үйлчилгээний орлого телефон цэгийн тоо 25-26
16. Дүгнэлт27-28
17. Ашигласан ном, материал29

Аймгийн аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын үүсэл хөгжил

Өвөрхангай аймаг 1942 онд Улсын бага хурлын шийдвэрээр 23 сум 177 баг, 15000 өрхтөйгөөр анх байгуулагдсан юм. Эдүгээ аймаг засаг захиргааны нэгжийн хувьд 19 сум, сум нь 109 багт хуваагддаг. 1991 оноос нийгэм бүхэлдээ өөрчлөгдөн улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж бүх салбарын төрийн өмч хувьчлагдан хувьд шилжсэнээр ихэнхи салбаруудад хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж жижиг дунд үйлдвэрүүд шинээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Аж үйлдвэр

Аймгийн хүнсний үйлдвэр нарийн боов талх, чихэр, архины цехтэйгээр 1961 онд ашиглалтанд орсноор аймгийн ард иргэдийг үйлдвэрийн аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр үйлчилж эхэлжээ.

Хархорин суманд 1972 онд спиртын үйлдвэр , 1983 онд хүнсний үйлдвэрүүд тус тус ашиглалтад орсон .

Баянтээгийн нүүрсний уурхай нь 1961 онд байгуулагдах үедээ жилд 20 мянган тонн нүүрс олборлох хүчин чадалтай байв. Ордны хайгуулын нөөц 160 сая тонн бөгөөд Өвөрхангай, Архангай, Баянхонгор аймгуудыг нүүрсээр хангадаг.

Уянга суманд үйл ажиллагаа явуулж буй 40-өөд алт олборлох нөхөн сэргээх чиглэлийн жижиг бичил уурхай эрхлэгч компаниуд үйл ажиллагаа явуулж байна.

1950 оны эхээр аймгийн төвд дизель цахилгаан станц ажиллуулж эхэлсэн ба 1965 онд Эрчим хүчний үйлдвэр болон өргөжүүлжээ.

1991 онд бүтцийн өөрчлөлтөөр нийтийн аж ахуйн үйлчилгээний газартай нэгтгэж аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэр, 1995 оноос хойш Эрдэнэтийн цахилгаан шугам сүлжээний газрын харъяа Өвөрхангай аймгийн цахилгаан шугам сүлжээний салбар байгуулагдсан байна.

Төр засгийн зүгээс жижиг бизнесийг хөгжүүлэх ажлыг төрийн бодлого болгож, жижиг бизнес эрхлэх, шинээр үүсч бий болох таатай орчныг бүрдүүлж, үр ашигтай жижиг аж ахуйнуудыг цаашид хөгжин дэвшихэд нь дэмжин туслах зорилгоор хөтөлбөр боловсруулан тодорхой арга хэмжээнүүдийг авч явуулсны үр дүнд орон нутгийн зах зээлд тэдний үйлдвэрлэл нэмэгдэж байна.

2015 оны эцсийн байдлаар аж үйлдвэрийн салбарт бүртгэлтэй 200 орчим аж ахуй нэгж байгууллага болон 300 орчим цэг салбар байна. Уул уурхайн 36, хүнсний бүтээгдхүүн үйлдвэрлэлийн 40 орчим, бусад нэр төрлийн үйлдвэрлэлийн чиглэлээр /модон эдлэл, барилгын материалын үйлдвэрлэл, цахилгаан, дулаан, хэвлэх, ус суваг, гм / 124 газар бүртгэлтэй 76 % нь үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн барилгын салбарын бодлогын асуудлыг Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хариуцан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд барилгын салбарын 30-аад аж ахуй нэгж бүртгэлтэй байгаагаас тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа 20 аж ахуй нэгж байна.

Бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын тоо

2015 онд бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо 1628 байна. Хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл төсөвт байгууллага 211, ХК 10, ХХК 734, салбарууд 110, хоршоо 189, ЗБН 36, ББН 56, төрийн бус байгууллага 216, ОНБайгууллага 18, хадгаламж зээлийн хоршоо 7, шашны байгууллага 11 байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын тоо
/ сум, хариуцлагын хэлбэрээр 2015 он/


Хүснэгт-1

	Бүх аж ахуйн нэгж	Төсөвт байгууллага	Салбар	ЗБН	ББН	ХК	ХХК	ОНӨҮГ	ТӨҮГ	Хоршоо	Хад.зээлийн хоршоо	Төрийн бус байгууллага	Шашны байгууллага	Сан	Олон нийтийн байгууллага
Бүгд	1628	211	110	36	56	10	734	21	1	189	7	216	11	8	18
Баян-Өндөр	43	7	2	-	5	-	10	1	-	7	-	11	-	8	18
Бүрд	21	6	2	1	1	-	1	1	-	7	-	3	-	-	-
Бат-өлзий	81	7	3	2	3	-	38	1	1	17	-	8	1	-	-
Баруунбаян															
-Улаан	20	6	2	-	1	-	5	1	-	5	-	-	-	-	-
Баянгол	36	8	2	-	4	-	7	1	-	4	1	9	-	-	-
Гучин-Ус	30	6	2	1	3	-	5	1	-	7	1	4	-	-	-
Есөнзүйл	34	6	2	2	1	-	12	1	-	6	-	4	-	-	-
Өлзийт	32	6	2	1	-	-	12	1	-	7	-	3	-	-	-
Зүүнбаян-															
Улаан	38	7	3	-	5	-	6	1	-	14	1	1	-	-	-
Богд	39	6	2	-	1	-	12	1	-	11	-	6	-	-	-
Нарийнтээл	42	10	3	1	2	-	10	1	-	13	-	2	-	-	-

Сант	24	7	2	1	3	-	4	1	-	6	-	-	-	-
Тарагт	33	7	2	1	2	-	9	1	-	10	-	1	-	-
Төгрөг	30	7	2	1	-	-	6	1	-	4	-	9	-	-
Уянга	79	10	5	2	2	-	44	1	-	8	-	4	2	-
Хайрхандул аан	31	6	2	1	1	-	10	1	-	10	-	-	-	-
Хужирт	69	8	5	-	3	2	33	1	-	11	1	3	2	-
Хархорин	175	22	21	3	3	4	80	2	-	7	1	25	3	2
Арвайхээр	771	69	46	18	16	4	430	2	-	36	2	123	3	6


Зураг-1

Бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын тоо



Зураг-2

Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулж
буй аж ахуйн нэгж салбараар



Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 45.1 хувь нь ХХК, 13.0 хувийг төсөвт байгууллага, 11.7 хувийг хоршоо, 3.4 хувийг ББН, 13.3 хувийг ТББ,бусад 13.0 хувийг тус тус эзэлж байна.

Сүүлийн жилүүдэд аж үйлдвэр, барилга үйлчилгээний

салбарт гарч байгаа онцлог, өөрчлөлт

Сүүлийн жилүүдэд уул уурхайн хөгжлөө дагаад тус аймгийн нутаг дэвсгэрт аж ахуйн нэгжүүд алт олборлолтийн үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч аймгийн төсөв, орон нутгийн орлогод бага нөлөө үзүүлдэг. Ихэнх нь УБ хотын харъяат аж ахуйн нэгжүүд байдагтай холбоотой.

Аймгийн хэмжээнд барилга байшин ихээр баригдаж байгаагийн зэрэгцээ барилгын материал блок, тоосго үйлдвэрлэх жижиг үйлдвэрлэгчид бий болж аймгийнхаа нутаг дэвсгэрт байгаа түүхий эд материалыг түшиглэн үйлдвэрлэл эрхэлж байгаа нь тээврийн зардал багатай талаас нь харгалзаж хэрэглэгчдэд өртөг бага тусч борлуулалт сайн байгаа нь үйлдвэрлэгчид бүтээгдэхүүний чанар, технологио сайжруулж үйлдвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлж ажиллавал илүү үр дүнд хүрэх бололцоотой.

Барилга нэмэгдэхийн зэрэгцээ халаалтын жижиг зуухнуудын тоо нэмэгдэж агаарын бохирдол их хэмжээгээр нэмэгдэж утаатай аймгийн тоонд яах аргагүй орж байгаа сөрөг тал бий болсон байна.Ийм учраас дулааны цахилгаан станцыг ойрын хугацаанд барьж байгуулах асуудал тулгамдсан асуудал болж байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт

Аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагаа нь хүн амын хэрэглээ,дэд бүтэц болон ашигт малтмалын нөөц ,уул уурхайн газар зүйн байршилаас илүү хамааралтай бөгөөд боловсруулах аж үйлдвэрийн салбар нь ихэнхдээ хүн амын хэрэглээг хангахад оршдог.

Аж үйлдвэрийн салбарт 2015 онд 32369.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оныхоос 6.0 хувиар буюу 1821.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хангайн бүсийн аймгуудын аж үйлдвэрийн

салбарын борлуулсан бүтээгдэхүүн,оны үнээр, сая төг

Хүснэгт-2

	2014	2015*	2015/2014 %
Архангай	5 028.0	5 865.7	116.7
Баянхонгор	4 991.6	4 915.7	98.5
Булган	9 857.3	13 299.4	134.9

Орхон	1 436 156	1 309 217.1	91.2
Өвөрхангай	29 980.7	31 904.0	106.4
Хөвсгөл	10 074.6	12 399.9	123.1
Хангайн бүс	1 488 070.4	1 377 601.8	92.6


Хангайн бүсийн аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оноос 7.4 хувиар буурсан ба бүс дотроо Орхон аймаг үйлдвэрлэлт, борлуулалтаараа дийлэнхи буюу 95.0 хувийг дараа нь манай аймаг 2.3 хувийг эзэлж байна.

Аймгийн аж үйлдвэрийн салбарын
нийт үйлдвэрлэлт / сая.төг/

Хүснэгт-3

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	2015	2015/2014%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	3373.8	5450.7	9820.2	10353.1	105.4
Боловсруулах аж үйлдвэр	8292.3	12650.0	15093.2	16218.8	107.5
Хүнсний бүтээгдэхүүн	4470.6	7370.7	7902.1	8045.6	101.8
Мод модон эдлэл	1899.3	1267.6	1568.3	2001.7	127.6
Хэвлэл	36.4	37.3	56.6	39.6	70.0
Оёмол бүтээгдэхүүн	281.9	479.0	683.5	888.7	130.0
Гутал	196.9	493.2	587.3	694.7	118.3
Тоосго	541.7	968.4	1059.3	851.9	80.4
Блок	511.5	1025.3	1484.9	900.3	60.6
Бусад/ нүдний шил, хайрга, вакум цонх, төмөр хийц, угаасан ноос, гэх мэт/	354.0	1008.5	1751.2	2796.3	159.7
<i>Дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж</i>	<i>4386.0</i>	<i>4542.0</i>	<i>5634.4</i>	<i>5797.3</i>	<i>102.9</i>
Нийт дүн	16052.1	22642.7	30547.8	32369.2	106.0

Нийт үйлдвэрлэлт салбараар



Аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбар дотроо уул уурхай олборлох аж үйлдвэрийнх 32.0 хувийг, боловсруулах салбарынх 50.1 хувийг, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарынх 17.9 хувийг тус тус эзэлж байна.


Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт / сая.төг/

Хүснэгт-4

Үзүүлэлтүүд	2013	2014	2015	2015/2014 %
Нийт дүн	22006.4	29980.7	31904.0	106.4
Нүүрс олборлолт	1829.2	2096.3	2231.7	106.5
Алт олборлолт	3621.4	7723.8	8121.3	105.1
Хүнсний бүтээгдэхүүн	7272.8	7808.8	7948.7	101.8
Мод модон эдлэл, тавилга	1247.5	1512.3	1976.7	130.7
Гутал үйлдвэрлэл	436.3	547.1	631.4	115.4
Оёмол бүтээгдэхүүн	472.2	683.4	863.7	126.4
Тоосго	749.7	985.2	736.4	74.7
Блок	997.8	1381.0	880.4	63.7
Бусад/ нүдний шил, хайрга, вакум цонх, төмөр хийц, угаасан ноос, гэх мэт/	837.6	1608.4	2716.4	168.9
Дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	4541.9	5634.4	5797.3	102.9

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн оны үнээр 31904.0 сая төгрөгт хүрч, үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 5.4 хувь буюу 10353.1 сая.төгрөг, боловсруулах аж үйлдвэрийн салбарынх 49.4 хувь буюу 15753.6 сая.төгрөг, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарынх 18.2 хувь буюу 5797.3 сая.төгрөг байна.

Зураг-4



Аж үйлдвэрийн борлуулалт 2014 онд өмнөх оноос 106.4 хувь буюу 1923.3 сая төгрөгөөр нэмэгджээ.

Аймгийн газар зүйн байршил зах зээлд ойр эсэх

Өвөрхангай аймаг нь 63.5 мянган кв.км нутаг дэвсгэртэй бөгөөд нутгийн хилийн урт 1250 км, өмнөд цэгээс хойд цэг хүртэл 420 км, баруун цэгээс зүүн цэг хүртэл 300 км нутаг дэвсгэртэй болно.Хөрш зэргэлдээ 6 аймагтай хиллэдэг юм.

Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хангайн бүсийн нутаг дэвсгэрт харъяалагдана. Уур амьсгалын үндсэн нөхцлийг хэрэглээний зориулалтаар судлан боловсруулах, үнэлэх нь тус аймгийн мал аж ахуйн хөгжил өсөлт, газар тариалангийн үйлдвэрлэл, аялал жуулчлал эрхлэх, рашаан сувилал, хүний эрүүл мэнд, хөдөлмөрийн нөхцөлийг үнэлэх, зам, барилга байгууламж байгуулах болон ашиглалтыг сайжруулах,үйлдвэрлэл үйлчилгээ явуулах, хөрөнгө оруулалт хуваарилалтын бодлогод шууд ашиглагдах болно. Өвөрхангай аймгийн уур амьсгал нь эх газрын эрс тэс, тэгш хэмийн хуулийн хуваарилалттай, жилийн дөрвөн улирлын хэв шинж өнгөтэй байдаг. Монгол орны уур амьсгал , түүний төвийн бүсийн Хангай говь хосолсон Өвөрхангай аймагт ч сүүлийн 50-60 жилд уур амьсгалын хэлбэлзэл үечлэл, өөрчлөлт дулаарал болж байна. Уур амьсгалын дулааралтыг дагаад аж ахуйг эрхлэн хөтлөх арга ажиллагаанд одоогоос уур амьсгалд дасан зохицох шаардлага тодорхой байх хэрэгтэй болж байгаа юм. Эдгээр нь тус бүс нутгийн нийгэм эдийн засгийн болон үйлдвэрлэл үйлчилгээ явуулах

аж ахуйг эрхлэх аливаа асуудлыг уламжлалт аргаар удирдан эрхлэн хөтлөх үйл ажиллагаанд шинэчлэлт хийхийг зүй ёсоор бий болгож байна.

Аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц, га-гаар

Хүснэгт-5

Сумын нэр	Нийт газар	үүнээс:					ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар
		ХАА-Газар	Бэлчээр	Хадлан	Тариалан	Атаршсан талбай	
Бүгд	6289533	5719721.5	5671079.0	6586.7	15957.9	22971.9	3126.0
Баян-Өндөр	324832.0	312111.7	310221.3	86.2	24.2	1602.4	177.58
Бүрд	258138.0	213320.3	210629.6	242.5	34.0	2349.56	64.69
Бат-Өлзий	242820.0	33727.8	32673.4	965.6	16.3	51.31	21.29
ББ-Улаан	394111.0	387465.7	387233.3	76.8	20.4	-	135.15
Баянгол	354257.0	351461.0	351206.7	-	24.9	-	229.48
Гучин-Ус	475250.0	463758.6	463608.9	-	11.0	-	138.75
Есөнзүйл	221088.0	218610.2	214362.3	1291.1	211.6	2627.83	117.45
Өлзийт	179705.0	177423.4	174995.0	242.7	20.3	2047.43	117.96
ЗБ-Улаан	270098.0	254071.1	251420.8	1608.7	334.0	597.78	109.8
Богд	1015519	960902.0	960432.4	-	64.2	-	405.49
Нарийнтээл	270170.0	264663.7	264503.8	42.0	31.2	11.07	75.71
Сант	256406.0	254586.0	254291.4	117.4	0.2	-	177.1
Тарагт	339544.0	310254.7	307261.5	323.5	287.9	2090.06	289.71
Төгрөг	546688.0	531381.5	531073.5	63.1	43.8	46.64	154.49
Уянга	313936.0	277499.7	276380.1	191.3	9.8	607.96	310.62
Х-дулаан	413770.0	408850.0	408612.1	69.4	19.0	-	149.52
Хужирт	171782.0	125233.7	122604.9	1115.9	298.7	1015.54	198.64
Хархорин	224116.0	168882.6	144093.8	150.7	14461.3	9924.3	252.57
Арвайхээр	17303.0	5519.7	5474.3	-	45.4	-	-

Хүснэгт-5-ийн үргэлжлэл

Сумын нэр	үүнээс:				
	Хот тосгон бусад суурины газар	Зам шугам сүлжээний газар	Ойн сан	Усан сан	Улсын тусгай хэрэгцээний газар
Бүгд	43774.6	24134.0	150749.5	8248.6	342904.9
Баян-Өндөр	510	969.06	0.77	389.5	10851
Бүрд	589	1730.3	-	135.4	42363
Бат-Өлзий	7654.27	165.68	25530.7	81.9	175659.7
ББ-Улаан	590	1324.55	3100.0	1629.8	1
Баянгол	284.61	1724.17	-	786.2	1
Гучин-Ус	1099	1265.09	8800.0	326.3	1
Есөнзүйл	298.5	1311.92	611.0	255.4	1
Өлзийт	656	1220.83	-	404.8	-
ЗБ-Улаан	431.13	1741.76	13502	351.0	1
Богд	902.7	2040.06	51350.0	323.2	1
Нарийнтээл	4183.79	1021.48	-	309.7	2
Сант	99.23	1163.24	-	556.5	1
Тарагт	889.0	2844.22	-	440.3	25117.86
Төгрөг	1135.43	813.68	12500.0	856.4	1
Уянга	3370.17	960.3	19374.0	660.8	12071
Х-дулаан	1807.47	1845.34	766.0	500.2	1
Хужирт	4864.35	739.12	10628.5	125.1	30191.3
Хархорин	9507.98	973.81	4586.6	127.1	40038
Арвайхээр	4901.92	279.39	-	-	6602

Зураг-5

Манай аймгийн газар нутгийн бүтцийн 91.0 хувь нь хөдөө аж ахуйн газар, 2.0 хувийг хот суурингийн газар эзэлж байна.

Аймгийн дэд бүтцийн хөгжлийн байдал, зам харилцаа

эрчим хүчний эх үүсвэр

Өвөрхангай аймгийн 19 сум төвийн эрчим хүчний системд холбогдсон. Арвайхээрээс Баянхонгор хүртэлх 220 км аналог радио релейний шугам, Булганы Дашинчилэн сумаас Арвайхээр хүртэлх 230 км тоон релейний шугам ашиглагдаж байна.

Арвайхээрт сүүлийн үеийн тоон радио релейний станц, тоон радио релейний шугамтай. Өвөрхангай аймгийн хувьд дэд бүтцийн хөгжил, байгалийн баялаг, түүхий эд материалын хувьд үйлдвэрлэл явуулах боломж бүрэн байна гэж дүгнэдэг.

**Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн
бүтээгдэхүүн үйлдвэрлэлт**

Хүснэгт-6

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2013	2014	2015	2015/2014 %
Талх	тн	721.1	741.6	611.0	82.4
Нарийн боов	тн	862.1	817.2	675.2	82.6
Архи	мян.л	35.3	19.4	25.2	129.9
Бялуу	тн	7.0	6.7	8.9	132.8
Цэвэр ус	тн	7532.8	5934.2	5476.6	92.3
Сүү	мян.л	167.1	255.5	239.8	93.9
Тараг, хоормог, ааруул	мян.л	111.1	114.3	107.2	93.8
Хэрчсэн гурил, банш, Гурил	тн	96.0	156.5	171.6	109.6
Хиам	тн	7.9	15.1	9.6	63.6
Даршилсан ногоо	тн	6.1	7.7	3.1	40.3
Дулаан	мян.г.кл	110.0	129.6	129.8	100.2
Ус ариутгал усан хангамж	мян/м3	194.9	260.5	412.8	158.5
Нүүрс	мян.тн	91.6	104.8	111.5	106.4
Алт	кг	52.5	111.9	117.7	105.2
Гэрийн мод	шир	1552	1575	2179	138.3
Хүснэгт, маягт	мян.ш х	103.4	145.1	101.0	69.6
Гутал	хос	6581	6593	8203	124.4
Тоосго	мян,ш	2735.5	3202.7	2790.6	87.1
Блок	мян.ш	970.9	1033.9	836.5	80.9
Хайрга	м3	-	6100	-	-
Бетон зуурмаг	м3	-	1088.7	-	-
Угаасан ноос	тн	-	1500	790.5	-
Вакум цонх	м2	4774.5	4791	3115	65.0
Хивэг	тн	34.0	18.4	5.0	27.2

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг авч үзэхэд 2015 онд нүүрс олборлолт, дулааны эрчим хүч, усан хангамж, архи, бууз банш, хэрчсэн гурил, оёмол бүтээгдэхүүн, гутал, гэрийн мод, алт, зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.0 -58.5 хувиар нэмэгдсэн байна. Харин цэвэр ус, талх, сүү сүүн бүтээгдэхүүн, хиам, хүнсний давс, ном, хүснэгт маягт, блок, тоосго, угаасан ноос, эсгий үйлдвэрлэлт 6.1-59.7 хувиар буурсан байна.


Хангайн бүсийн аймгуудын дотоодын

нийт бүтээгдэхүүн, оны үнээр

Хүснэгт-7

	2014				2015			
	ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь			ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь		
		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ
Архангай	393 914.7	60.1	16.0	23.9	393 776.8	63.9	13.6	22.5
Баянхонгор	331 491.4	52.1	13.5	34.4	349 375.7	51.7	17.4	30.9
Булган	315 738.7	59.5	18.6	21.9	307 915.0	61.5	16.8	21.8
Орхон	1 197 558.4	1.7	83.1	15.3	1 315 632.9	1.1	83.9	15.0
Өвөрхангай	389 718.5	50.6	14.8	34.6	407 747.2	52.4	16.1	31.5
Хөвсгөл	463 985.5	44.9	21.3	33.8	471 957.9	46.2	21.8	32.0
Хангайн бүс	3 092 407.2	33.1	42.6	24.3	3 246 405.4	32.9	44.3	22.8
Улсын дүн	21 937 159.4	14.0	36.1	49.9	23 166 779.2	13.6	34.1	52.3

Дотоодын нийт бүтээгдэхүүн дэх аж үйлдвэр, барилга, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбаруудын эзлэх хувийг доорх графикт харуулав.



2015 онд аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 407.7 тэрбум төгрөг болсон ба өмнөх оноос 18.0 тэрбум төгрөгөөр буюу 4.6 хувиар өсчээ. Үүнээс аж үйлдвэр, барилгын салбарынх 65.6 тэрбум төгрөг буюу 16.1 хувийг эзэлж байна. Өмнөх оноос үйлдвэр, барилгын салбарын ДНБ 7.9 тэрбум төгрөгөөр буюу 13.7 хувиар өссөн байна. Аж үйлдвэрийн салбарын ДНБ-ийг бүсээр авч үзэхэд хамгийн их нь Орхон 1103.8 , Хөвсгөл 102.8, Өвөрхангай 65.6, Баянхонгор 60.8 Булган 51.7, Архангай 63.0, тэрбум төгрөг тус тус байна. Манай аймгийн ДНБүтээгдэхүүн 2015 онд хангайн бүсэд 12.6 хувь, улсын дүнд 1.8 хувийг эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарт ажиллагсадын тоо,

аймгийн нийт ажиллагчдад эзлэх хувь

Аймгийн аж үйлдвэрийн салбарт ажиллагсадын тоо өмнөх жилээс 1260 хүн буюу 19.4 хувиар буурчээ. Аж үйлдвэрийн салбарт ажиллагсад аймгийн нийт ажиллагсадын 10.2 хувийг эзэлж байна. Нийт үйлдвэрийн ажиллагсадын 28.8 хувь нь боловсруулах үйлдвэрийн, 32.5 хувь нь уул уурхайн, 34.5 хувь нь барилгын, 4.2 хувь нь цахилгаан, дулаан, усан хангамжийн салбарт ажиллаж байна.


Хүснэгт-8

Дэд салбаруудаар	2014	2015	2015/2014
Уул уурхай	1386	1704	122.9

Боловсруулах үйлдвэр	2468	1510	38.8
Цахилгаан,дулааны эрчим хүч	1270	224	-
Барилга	1382	1808	130.8
Аж үйлдвэрийн салбарт ажиллагсад	6506	5246	80.6
Нийт ажиллагсад	52538	51415	2.2
Аж үйлдвэрийн салбарын ажиллагсадын нийт ажиллагсадад эзлэх хувь			
	12.4	10.2	17.7


Зураг-6

Нийт ажиллагсадад уул уурхайн салбарт ажиллагсадын эзлэх хувь




Зураг-7

Боловсруулах салбарт ажиллагсадын эзлэх хувь



Цахилгаан, дулаан, усан хангамжийн салбарт

ажиллагсадын эзлэх хувь




Барилгын салбарын нийт үйлдвэрлэлт,

их засварын ажлууд /сая.төг/

Хүснэгт-9

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Барилга угсралтын ажил	5735.3	4134.6	5095.6	11415.2	17893	21300.5	24136.6	39850.3	18628.2
Их засварын ажил	2893.6	2703.6	2872.5	1486.3	2625.4	3345	2109.7	3604.7	3131.6
Авто зам засвар, арчлалт	2354.7	2371.4	1438.3	4292.5	5063.6	10921.6	32975.6	7691.7	6459.0
Дүн	10983.6	9209.6	9406.4	17194	25582	35567.1	59221.9	51146.7	28218.8

Барилга угсралт, их засвар, зам засвар, арчлалт, 2007-2015 он



2015 онд хийсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээг 2007 оныхтой харцуулахад 34826.1 сая төгрөг буюу 4 дахин өссөний дотор барилга угсралтын ажил 34115.0 сая төгрөг буюу 5.9 дахин, их засвар 711.1 сая төгрөг буюу 3.6 дахин, зам засвар, арчлалт 5337.0 сая төгрөг буюу 2.0 дахин нэмэгдсэн байна.

Аж үйлдвэр, барилгын салбарын

хөдөлмөрийн бүтээмж

Бүтээмж нь улс оронд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлт бөгөөд нэгж зардлаар хэдий хэр бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэж байгааг тодорхойлдог.

Хөдөлмөрийн бүтээмжийг тооцохдоо нэмэгдэл өртгийн хэмжээг жилийн дундаж ажиллагчдын тоонд хувааж гаргадаг. Аймгийн аж үйлдвэр, барилгын салбарын хөдөлмөрийн бүтээмжийн хэмжээ урьд оноос 3.7 пунктээр нэмэгдсэн байна.


Хүснэгт-10

Үзүүлэлт	2013	2014	2015	2015/2014 %	Зөрүү
Аж үйлдвэр, барилгын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн/ сая төг/	45780.7	57678.3	65657.3	113.8	7979.0
Аж үйлдвэр, барилгын салбарын ажиллагсадын дундаж тоо	7716	6506	5246	80.6	-1260

Үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж	5.9	8.8	12.5	142.0	3.7
---	-----	-----	------	-------	-----

Зураг-10

Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж




Худалдаа, үйлчилгээний салбарын өнөөгийн байдал, нэмэгдэл өртгийн хэмжээ аймгийн ДНБ-д эзлэх хувь

Аймгийн хэмжээнд 2015 онд бөөний болон жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй /БРСанд/ 232 аж ахуй нэгж байгаагийн 161 буюу 69.3 хувь нь үйл ажиллагаа эрхэлж байна. ДНБ-ний тооцоонд БРСанд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй эдгээр 161 аж ахуй нэгж /албан/ болон түүвэр судалгааны мэдээлэл, бусад мэдээллийн эх үүсвэрийг /албан бус/ ашиглан тооцсон. 2015 онд ДНБ оны үнээр 177683.4 сая төгрөгт хүрсний 30043.3 сая төгрөг буюу 16.9 хувь нь худалдааны салбарт бий болсон байна.

Худалдаа, үйлчилгээний салбарын ДНБ-ний гүйцэтгэл, /сая.төг/ оноор, хувиар:

он	2012	2013	2014	2015	Хүснэгт-11	
					2015/2014 зөрүү	%
Бүгд ДНБ	206878.9	307253.1	389718.5	407747.2	18028.7	104.6
Худалдаа, үйлчилгээний салбар	81924.0	98320.9	134842.6	128440.4	-6402.2	95.3
ДНБ-д эзлэх хувь	39.6	32.0	34.6	31.5	-3.1	91.0

Худалдаа, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг



Хүснэгт-12

Үзүүлэлт	Цэгийн тоо	
	2014 он	2015 он
Барааны дэлгүүр	238	208
Хүнсний дэлгүүр	494	513
Үүнээс: согтууруулах ундааны гүйлгээ	312	316
Авто засвар	32	41
Барилгын материалын дэлгүүр	18	25
ТҮЦ	15	5
Контейнер	269	171
Шатахууны борлуулалт	56	56
Ресторан, бар	38	36
Цайны газар	77	86
Эм борлуулалт	46	47
ДҮН	1388	1253

2015 онд нийт 1253 ААНэгж, цэг тооцоонд хамрагдсан нь өмнөх оноосоо 135 нэгжээр буюу 9.7 хувиар буурсан байна. Үүний хамгийн их бууралт нь нь контейнер салбарт буюу 36.5 хувийн бууралттай гарсан байна.

Худалдаа, үйлчилгээний салбарын хөдөлмөрийн бүтээмж

Бүтээмж нь үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлт бөгөөд нэгж зардлаар хэр хэмжээний бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэж байгааг тодорхойлдог. Бүтээмжийн үндсэн үзүүлэлтүүдийн нэг болох хөдөлмөрийн бүтээмжийг тооцоходоо нэмэгдэл өртгийн хэмжээг жилийн дундаж ажилчдын тоонд харьцуулна.


Хүснэгт-13

Үзүүлэлт	2012	2013	2014	2015
Худалдаа, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг/сая.т/	81924.0	98320.9	134842.6	128440.4
Салбарын нийт ажиллагсад	5205	5598	6836	5295
Хөдөлмөрийн бүтээмж	15.7	17.5	19.7	24.3

Худалдаа, үйлчилгээний салбарын хөдөлмөрийн бүтээмж жилээс жилд өссөн хандлага ажиглагдаж байна.

Зураг-13

Худалдаа, үйлчилгээний салбарын хөдөлмөрийн бүтээмж



Тээврийн салбарын үзүүлэлтүүд

Тээврийн салбарын статистик үндсэн үзүүлэлтүүд ачаа эргэлт, тээсэн ачаа, зорчигч эргэлт, авто машины тоо, шилжүүлсэн тонн,км ажиллагсдын тоо орлого зэрэг орно.

Ачаа эргэлт Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг зөөвөрлөсөн зайгаар үржүүлсэн үзүүлэлт

Зорчигч эргэлт Нийт зорчигчдын тоог тээвэрлэсэн зайгаар үржүүлсэн хэмжээ

Шилжүүлсэн тонн км Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл хэлбэрийн ажил үйлчилгээг тусгай коэффициентийг ашиглан нэг нэгжид шилжүүлж тооцно.


Хүснэгт-14

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2011	2012	2013	2014	2015	2015/2014
Нийт орлого	сая.төг	1774.2	1983.9	2001.5	2115.2	2258.4	106.8
Ачаа эргэлт	мян.тн.км	11699.3	12546.0	12925.7	13802.0	14850.3	107.6
Тээсэн ачаа	мян.тн	34.3	36.9	38.3	41.2	44.3	107.5
Зорчигч эргэлт	мян.хүн.км	54260.1	59883.5	61316.0	63452.0	67200.1	105.9
Зорчигчид	мян.хүн	198.5	217.5	220.6	228.2	243.3	106.6

Тээсэн ачаа 2014 оныхоос 7.5 хувь буюу 3.1 мянган тонноор, зорчигчдын тоо 6.6 хувь буюу 15.1 мянган хүнээр тус тус өслөө. Тээврийн үйлчилгээний орлого 2258.4 сая төгрөгт хүрч өмнөх оноос 142.9 сая төгрөг буюу 6.8 хувиар нэмэгдсэн байна.

Зураг-14

Тээврийн орлого




Техникийн үзлэгт хамрагдсан
автомашины тоо, бүсээр

Хүснэгт-15

Аймаг	2013	2014	2015	Өсөлт, бууралт
Архангай	5396	5276	5435	159
Баянхонгор	5568	5425	5917	492
Булган	5237	6016	7100	1084
Орхон	11121	12497	14276	1779
Өвөрхангай	5812	5887	6010	123
Хөвсгөл	9671	10908	10593	315
Хангайн бүс	42805	46009	49331	3322

Зураг -15

Өвөрхангай аймгийн автомашины
тоо, төрлөөр




Холбооны салбарын үзүүлэлтүүд

Хүснэгт-16

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2015/2014
Харилцаа холбооны үйлчилгээний орлого, сая. төг	298.3	320.2	519.2	547.2	581.6	106.3
Үүнээс: Хүн амаас орсон орлого, мян төг	59.6	155.2	175.2	179.3	163.2	91.0
Суурин утасны цэг	1022	1016	1008	981	976	99.5
Үүнээс: өрхийн хэрэглэгч	560	541	514	509	505	99.2
Үүрэн утас хэрэглэгчийн тоо, (давхардсан тоогоор)	55737	63742	68385	72045	84800	117.7
Кабелийн телевизийн хэрэглэгчдийн тоо	1104	1174	2431	2735	3556	130.0
Интернэтээр үйлчлүүлэгчдийн тоо	6250	10150	10165	10750	10800	100.5
Интернэтийн орлого сая. төг	90.5	159.0	153.2	170.6	136.3	79.9


Зураг-16



Харилцаа холбоо эрчимтэй хөгжиж байгаа өнөө үед манай аймагт хэд хэдэн үүрэн телефоны сүлжээ бий болсон юм.Үүнд: Мобиком, Ньютель,Жимобайл,Скайтель зэрэг операторууд үйл ажиллагаа явуулж байгаа ба үүрэн утасны хэрэглэгчдийн тоо нэмэгдэж, давхардсан тоогоор 84.8 мянгад хүрсэн нь өмнөх оныхоос 12.7 мянга буюу 17.7 хувиар өсчээ. Суурин утасны цэгийн тоо 976 болж, өмнөх оныхоос 5-аар буурчээ. Кабелийн телевизийн хэрэглэгчдийн тоо 3556 болж өмнөх оноос 821 хэрэглэгчээр нэмэгдсэн байна. Холбооны байгууллагууд 581.6 сая төгрөгийн орлоготой ажилласны 28.1 хувийг хүн амын үйлчилгээний орлого эзэлж байна. Өнгөрсөн оноос нийт орлого 6.3 хувиар буюу 34.4 сая.төгрөгөөр өсчээ. Интернетээр үйлчлүүлэгчдийн тоо 10800 болж өнгөрсөн оныхоос 5.0 хувиар өссөн ба 136.3 сая.төгрөгийн орлоготой ажилласан байна.


Суурин утас хэрэглэгчдийн тоо, хангайн бүсийн
аймгуудаар, 2015 он

Зураг-17



Зураг-18

Тээвэр, Холбооны салбарт ажиллагсад



ДҮГНЭЛТ,САНАЛ

Хэдийгээр аймгийн аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт, борлуулалтын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа боловч бүтээгдэхүүний чанар, өнгө үзэмж, хаяг шошгын асуудал шаардлага бүрэн хангаж чадахгүй байгаа юм. Аймгийн хэмжээнд төдийгүй бусад зэргэлдээ аймаг цаашлаад хил худалдаагаар гаргах хэмжээний үйлдвэрлэл явуулж чадахгүй байна. Анх 1940-өөд онд байгуулагдсан Хүнсний үйлдвэр талх, нарийн боов, архи үйлдвэрлэлт голлон үйлдвэрлэдэг ч чанартай холбоотойгоор бүтээгдэхүүний борлуулалт хангалттай биш. Нөгөө талаар хувийн худалдаа эрхлэгчид УБ хотоос бүтээгдэхүүн их хэмжээгээр оруулж ирж худалдаалж байгаа нь орон нутгийн үйлдвэрлэгчдийн борлуулалтад шууд нөлөөлж байна. 2008 оны үед зах зээлийн хөгжил хүн амын хандлагаа дагаад архины олон үйлдвэрүүд бий болж аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлтийг нэмэгдүүлж харагдаж байсан. Харин сүүлийн жилүүдэд орон нутгаас хяналтыг сайжруулж ихэнхийг нь хаасан. Уул уухайн чиглэлээр Баянтээгийн нүүрсний уурхай аж үйлдвэрийн салбарт голлох нөлөөтэй үйлдвэр юм. Аймгийн төдийгүй хил залгаа Баянхонгор, Архангай аймагт нийлүүлэлт хийдэг, эрэлтийг хангах хэмжээний нөөцтэй.

Сүүлийн жилүүдэд тус аймгийн нутаг дэвсгэрт аж ахуйн нэгжүүд алт олборлолтийн үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч аймгийн төсөв, орон нутгийн орлогод бага нөлөө үзүүлдэг. Ихэнх нь УБ хотын харъяат аж ахуйн нэгжүүд байдагтай холбоотой. Мөн барилгын хөгжлийг дагаад блок, тоосго үйлдвэрлэх жижиг үйлдвэрлэгчид бий болж байна. Тээврийн зардал багатай талаас нь харгалзаж хэрэглэгчдэд өртөг бага тусч байгаагаас борлуулалт сайн байгаа нь үйлдвэрлэгчид бүтээгдэхүүний чанар, технологую сайжруулж үйлдвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлж ажиллавал илүү үр дүнд хүрэх бололцоотой. Дулааны үйлдвэрлэлийн чиглэлээр жижиг зуухнууд бий болж дулаан үйлдвэрлэлт нэмэгдэж байгаа ч нөгөө талаар агаарын бохирдол их хэмжээгээр нэмэгдэж утаатай аймгийн тоонд яах аргагүй орж байна. Ийм учраас дулааны

цахилгаан станцыг ойрын хугацаанд барьж байгуулах асуудлыг шийдвэрлэх нь тулгамдсан асуудал юм.

Судалгаанаас дүгнэж харахад манай аймгийн боловсруулах аж үйлдвэрийн салбарын жин аж үйлдвэрийн нийт салбарын 50.1 хувийг боловсруулах үйлдвэрийн салбар, уул уурхай олборлох аж үйлдвэрийн салбарынх 32.0 хувийг, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлт, усан хангамжийнх 17.9 хувийг, хувийн жинг тус тус эзэлж байна. 2007 оноос барилгын үйл ажиллагаа нэмэгдэж орон нутгийн барилгын чиглэлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжсэн бодлого баримталснаар зарим барилга угсралт, их засварын ажлыг аймгийн аж ахуйн нэгжүүд хийснээр аймгийн барилгын салбарын үйл ажиллагаа сэргэж эхэлсэн. Тогтмол ажилчидтай болж материаллаг баазаа бэхжүүлж тендерт оролцож шаардлага хангаж жилд нэг аж ахуйн нэгж 2-3 ажил гүйцэтгэх болсон нь ихээхэн ахицтай байна.

Барилгын гүйцэтгэгч байгууллагууд 28.2 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг 110 объектод хийж гүйцэтгэсний 11.0 хувь буюу 3.1 тэрбум төгрөг нь их засварын ажил байна.

Аймгийн тээврийн салбарын дийлэнх нь хувийн тээврийн үйлчилгээ зонхилж байгаа бөгөөд тээврийн ачаа болон зорчигч тээврийн орлого үйлчилгээний хэмжээ өссөн үзүүлэлтэй байна.

Холбооны салбарын хувьд түлхүү хөгжиж ирсэн нь харагдаж байна. Тус аймаг шилэн кабелийн сүлжээнд холбогдож, техник технологийн шинэчлэлт хийсэн нь олон давуу талыг харуулж байна

Гэвч үүрэн телефоны операторууд манай аймагт иргэд хөдөлмөрчдийн хэрэгцээг хангаж ажиллаж байгаа нь нэг талаар сайн үзүүлэлт боловч, зах зээлийн өрсөлдөөн ихтэй, төвдөө төвлөрсөн удирдлагатай тайлан баланс гардаггүй гэдгээр манай статистик мэдээлэлд хамрагдах боломжгүй байдаг нь дутагдалтай. Аймгийн худалдаа, нийтийн хоолны цэг салбарууд 2015 онд 80.2 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь өмнөх оноос 11.8 хувиар өссөн байна. Тус аймгийн хувьд УБ хоттой 430 км-т засмал замаар холбогдсон, урагшаа хилийн боомт газруудтай ойр, төвийн эрчим хүчинд бүх сум холбогдсон зэрэг худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд боломжтой орчин бүрдсэн онцлогтой. Худалдааг эрхлэх хэлбэрээр нь авч үзвэл 75.0 гаруй хувь нь жижиглэнгийн, 25.0 хувь нь бөөний худалдаа эзэлж байгаагаас харахад сүүлийн жилүүдэд бөөний цэг, салбарууд олноор бий болсон байна..

Ашигласан материал, номзүй

- Статистикийн салбарт мөрдөж ажиллах аргачлалын эмхэтгэл 2010 он
- ӨВ Статистикийн эмхэтгэл 2012-2015 он
- Макро эдийн засгийн статистик 2007 он
- Монгол улсын статистикийн эмхэтгэл-2015
- www.1212.mn